



**НИЙСЛЭЛИЙН ХАН-УУЛ ДҮҮРГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГЫН ТУШААЛ**

2018 оны 08 сарын 21 өдөр

Дугаар А/78

Улаанбаатар хот

**Эрт илрүүлэгийн үзлэг зохион
байгуулах тухай**

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Эрүүл мэндийн Сайдын 2018 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн Техникийн ажлын хэсэг байгуулах тухай А/173 дугаар тушаалыг үндэслэн ТУШААХ нь:


1. Эрүүл мэндийн яам, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, Солонгосын олон улсын эрүүл мэндийн сан болон Солонгосын иргэдийн сангийн санхүүжилтээр дүүргийн 12 дугаар хорооны “Био-Асралт” Өрхийн эрүүл мэндийн төвд хэрэгжүүлж байгаа “Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээнд мобайл технологийн хэрэглээг өргөжүүлэх нь” төслийн үйл ажиллагааны удирдамжийг нэгдүгээр хавсралтаар, төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Ажлын хэсгийг үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, сар бүрийн 05-ны дотор тайланг ЭМЯ, ДЭМБ-т хүргүүлэхийг Төслийн зохицуулагч /Г.Даваасүрэн/-д үүрэг болгосугай.

3. Төслөөс батлагдан нэмэлт санхүүжилтийн дансанд орсон есөн сая жаран мянга дөрвөн зуун /9.006.400/ төгрөгийг нэмэлт санхүүжилтийн данснаас гаргахыг Ерөнхий нягтлан /Д.Хишигсүрэн/-д зөвшөөрсүгэй.

4. Ажлын хэсгийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Чанарын албаны дарга /Э.Оюумаа/-д даалгасугай.

ДАРГА



Э.БОДЬЦЭЦЭГ

Хан-Уул Эрүүл мэндийн төвийн даргын
2018 оны 08 дугаар сарын 21-ны өдрийн
А/76 тоот тушаалын нэгдүгээр хавсралт

**ХУН-УУЛ ДҮҮРГИЙН 12 ДУГААР ХОРООНЫ “БИО-АСРАЛТ” ӨРХИЙН ЭРҮҮЛ
МЭНДИЙН ТӨВИЙН “ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗЛЭГ, ЭРТ ИЛРҮҮЛЭГ”
ЗОХИОН БАЙГУУЛАХ УДИРДАМЖ**

Нэг. Үндэслэл

Хан-Уул дүүргийн 12 дугаар хороо нь 2017 оны байдлаар нийт 6974 хүн ам бүртгэлтэйгээс суурин хүн ам 5937, хөдөлгөөнт хүн ам 1037 байна. Газарзүйн байршлын хувьд Улаанбаатар хотын төвөөс 25 км зайтай оршдог тул хөдөө орон нутгаас шилжиж ирсэн малчин өрх, орлого багатай иргэд, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд дийлэнх хувийг эзэлдэг. Насны ангиллын хувьд нийт хүн амын 36.8% нь 15 хүртэлх насны хүүхэд, 63.5 % нь 15-64 насныхан, 1.5% нь 64-ээс дээш насны иргэд болно.

12 дугаар хорооны хүн амын нас баралтын тэргүүлэх шатгаанд цусны эргэлтийн тогтолцооны өвчин, амьсгалын замын өвчлөл, осол гэмтэл эзэлж байна.

Артерийн даралт ихсэлт 40%, чихрийн шижин 40%, умайн хүзүүний хорт хавдарын эрт илрүүлэг 36% байгаа нь дүүргийн дунджаас 1-15%-иар доогуур үзүүлэлттэй байна.

ЭМЯ-ны удирдлага, арга зүйн дэмжлэгтэйгээр болон Дэлхийн эрүүл мэндийн байгууллага ба Солонгосын Олон Улсын Эрүүл Мэндийн Сан (KOFIH) –ын санхүүжилт, техникийн туслалцаатайгаар хэрэгжиж буй “Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээнд мобайл технологийн хэрэглээг өргөжүүлэх нь” төсөлд 2018 оны 2-р сараас хамрагдаж байна. Төслийн хүрээнд зорилтот хүн амын дунд эрүүл мэндийн үзлэг, эрт илрүүлэг зохион байгуулахаар төлөвлөлөө.

Төсөл нь тогтвортой хөгжлийн зорилт-2030-ын Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд бүх нийтийг хамруулах зорилтонд хүрэхэд “Хэнийг ч орхигдуулахгүй” зарчмыг дэмжин ажиллахад хувь нэмэр оруулна гэж үзэж байна.

Хоёр. Зорилго:

Эрүүл мэндийн анхан шатны түвшинд эрүүл мэндийн цогц тусламж, үйлчилгээ үзүүлэх чадавхийг дээшлүүлэн, зорилтот хүн амын ялангуяа эмзэг бүлгийнхний эрүүл мэндийн байдлыг сайжруулах.

Гурав. Хамрах хүрээ

1. ЭМТ-ийн эмч, ажилчид 8

2. Хан-уул дүүргийн 12 дугаар хорооны эмч, ажилчид 13
3. Хан-Уул дүүргийн, 12 дугаар хорооны 2967 хүн

Дөрөв. Төслийн зохион байгуулалт ба хэрэгжилтийн хугацаа:

1. **Зохион байгуулах, хэрэгжүүлэх байгууллага:** Хан-Уул дүүргийн эрүүл мэндийн төв, 12 дугаар хорооны “Био-Асралт” Өрхийн эрүүл мэндийн төв
2. **Удирдлага, арга зүйн дэмжлэг үзүүлэх байгууллага:** ЭМЯ, НЭМГ, ДЗДТГ, Хан-Уул дүүргийн 12 дугаар хороо
3. **Техникийн ба санхүүжилтийн дэмжлэг үзүүлэх байгууллага:** ДЭМБ ба КОФИН
4. **Төслийн зохицуулагч:** Өрхийн менежер Г.Даваасүрэн
5. **Төслийн хяналт үнэлгээний баг:** НЭМО дарга Б.Лувсанням
Өрхийн менежер Г.Даваасүрэн
Чанарын менежер Ц.Оюунчимэг
6. **Төсөв:** 9,006,400 төгрөг
7. **Хугацаа :** 2018 оны 06 сар – 12-р сарын 20

Тав. Үйл ажиллагаа:

1. Удирдлага зохион байгуулалтын талаар:

- Техникийн ажлын хэсэг
- Төслийг зохион байгуулах үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах
- Эрүүл мэндийн үзлэг, эрт илрүүлэг хийх багийг томилох, хуваарь гаргах
- Тусламж үйлчилгээ үзүүлэх зураглал гаргах
- Техникийн ажлын хэсгийн хурал зохион байгуулах

2. Эрүүл мэндийн үзлэг, эрт илрүүлэг зохион байгуулах:

- Төсөлд хамрагдсан айл өрхийн бүх гишүүдийг үзлэг, эрт илрүүлэгт хамруулах ба батлагдсан маягт, асуумжийн дагуу үзлэг зохион байгуулах
- Үзлэг, эрт илрүүлэгийг эрүүл мэндийн төвд суурилсан, гэрийн эргэлт, явуулын хэлбэрээр зохион байгуулах ба явуулын тусламж үйлчилгээг гэрийн эргэлттэй хослуулан нийт үзлэгийн 70%-иас багагүй байхаар зохион байгуулах
- Үзлэг, эрт илрүүлэгийг төслийн үйл ажиллагааны аргачлалд заасан урсгалын дагуу асуумж, биеийн эрүүл мэндийн үзлэг, эрт илрүүлэгийн оношлуур багаж, хэрэгсэл ашиглаж зохион байгуулах
- Иргэдэд эрүүл мэндийн мэдээлэл сургалт, сурталчилгаа хийх ба мэдлэг, дадлыг үнэлэх

- Зорилтот бүлгийн хүн амын дунд хийгдсэн эрүүл мэндийн үзлэгээр илэрсэн сэжигтэй тохиолдлын оношийг баталгаажуулах, эмчлэх, хяналтандаа авах

3. Хяналт, үнэлгээ, тайлагналт:

- Эрүүл мэндийн үзлэг, эрт илрүүлэгийн зохион байгуулалт, урсгал, багаж тоног төхөөрөмжийн ашиглалтын байдлыг хянах
- Төслийн үйл ажиллагаа, хамрагдалтын явцын мэдээний чанарыг хянах, сар бүр нэгтгэх, дүн шинжилгээ хийх
- Явцын мэдээ, тайланг сар бүрийн 5-ны өдөр ЭМЯ, ДЭМБ-д хүргүүлэх
- Эмч, эмнэлгийн ажиллагсад, иргэдийн сэтгэл ханамжийг үнэлэх
- Эцсийн тайлан боловсруулах, хэлэлцүүлэх

Зургаа. Хүлээгдэж буй үр дүн:

1. Хожуу оношлогоо, илрүүлгээс шалтгаалсан өвчлөл, нас баралтаас сэргийлнэ
2. Зорилтот хүн амын эрүүл мэндийн тусламж үйлчилгээ буюу эх хүүхдийн үзлэг, халдварт болон халдварт бус өвчний эрт илрүүлэг, оношлогоо, хяналтанд хамрагдалтын хувь нэмэгдэнэ
3. ЭМАШТУ-ний эрүүл мэндийн мэдээллийн тогтолцооны чадавх сайжирна